



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2022 оны 293 дугаар тогтоолын 3.4, 5.2 дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, 7 нэрийн, нийт 93,857,754.00 (ерэн гурван сая найман зуун тавин долоон мянга долоон зуун тавин дөрөв) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Гадаад харилцааны яаманд балансаас балансад шилжүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

139005547  
17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 06 дугаар сарын 22 ны өдрийн  
22 дугаар тогтоолын хавсралт

**"ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР"**  
**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БАЛАНСААС**  
**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСАНД**  
**ШИЛЖҮҮЛЭН БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Хөрөнгийн өртөг (төгрөг)
1	Хуралд оролцогчийн микрофон	Fully Digital Congress System Delegate Unit	14	1,612,690.00	22,577,660.00
2	Орчуулгын төхөөрөмжийн удирдлага	16 CHs Digital Infrared Transmitter	1	8,593,000.00	8,593,000.00
3	Дууны гаралтын төхөөрөмж	8 Channels Audio Output Device	2	5,639,607.00	11,279,214.00
4	Орчуулгын радиотар	35W Digital Infrared Radiator	3	8,166,960.00	24,500,880.00
5	2 чихний хүлээн авагчийн чихэвч	Headphone	200	50,160.00	10,032,000.00
6	Орчуулагчийн микрофон	Fully Digital Congress System Interpreter Unit	5	3,135,000.00	15,675,000.00
7	Чанга яригчийн тогтоогч /хөл	Speakers support	10	120,000.00	1,200,000.00
		<b>НИЙТ ДҮН</b>	<b>235</b>	<b>27,317,417.00</b> (хорин долоон сая гурван зуун арван долоон мянга дөрвөн зуун арван долоо)	<b>93,857,754.00</b> (ерэн гурван сая найман зуун тавин долоон мянга долоон зуун тавин дөрөв)